



КРЕДИТ  
ББСБ

**ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот  
2019

Хүчтэй. Хамтдаа.

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол	5
2	Эчнээ санал хураалтаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал	11
	2.1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга	12
3	Хурлаас гарах тогтоолын төсөл	26
4	Саналын хуудасны загвар	28

## ХУРАЛ ЗАРЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч таны энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ард Кредит ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид 2018 оны 8 сарын 2-ны өдөр хуралдаж, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн бөгөөд уг хурлаас гарсан 2018/12 тоот тогтоолоор доорх шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

- Нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчлөх;
- Компанийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчилсөнтэй холбогдуулан компанийн
- дүрмийн төслийг батлах;
- Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс хувьцаагаа олон нийтэд санал болгох асуудлыг шийдвэрлэсний дараа компанийн дүрмийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх;

Улмаар Ард Кредит ББСБ нь компанийн хэлбэрийг өөрчлөн, олон нийтэд хувьцаагаа арилжаалах хүсэлтээ холбогдох байгууллагуудад гаргасан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо /Цаашид "Хороо" гэх/ 2019 оны 1 сарын 9-ний өдөр 3 тоот тогтоол, Монголын Хөрөнгийн Биржийн 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/133 дугаар тушаалаар тус тус нийтэд санал болгосон үнэт цаасыг бүртгэсэн билээ.

Манай компани хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн 2019 оны 3 сарын 29-ний өдөр нээлттэй хувьцаат компанийн дүрэм болон гэрчилгээг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлэн албан ёсоор Хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн юм. Гэвч Хорооноос жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах үүднээс 2019 оны 3 сарын 29-ний өдөр УБЕГ-т бүртгүүлсэн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин хэлэлцүүлэх шаардлагыг бидэнд ирүүлсэн болно.

Иймд Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2019 оны 9 сарын 7-ны өдөр хуралдаж 2019/23 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахаар шийдвэрлэсэн бөгөөд хурлаар 2019 оны 3 сарын 29-ний өдөр УБЕГ-т бүртгүүлсэн компанийн дүрмийг хэлэлцэн батлахаар болсон байна. Жич: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх компанийн дүрэм нь УБЕГ-т бүртгүүлсэн дүрэм болно.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 9 сарын 7-ны өдөр

Дугаар 2019/23

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 73 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9 сарын 7-ны өдрийн эчнээ хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг эчнээ санал хураалтаар явуулсугай.
2. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх өдрийг 2019 оны 10 сарын 1-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудас хүлээж авах сүүлийн өдрийг 2019 оны 11 сарын 11-ний өдрөөр тус тус тогтоосугай.
3. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2019 оны 9 сарын 9-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2019 оны 9 сарын 11-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2019 оны 9 сарын 26-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 9 сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2019 оны 9 сарын 16-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
7. Хурлын даргаар Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг томилсугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Сүхбаатар

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Мөнхсүрэн

Маркетинг хариуцсан захирал Д.Сувдмаа

Зээл эрхэлсэн захирал Д.Отгонжаргал

Ерөнхий нягтлан бодогч Д.Дархижав

9. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Г.Сүхбаатар/-г даалгасугай.
11. Хурлын Тооллогын комиссоор Глобал Дийл ХХН-ийг томилж, дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай.

Тооллогын комиссын дарга: Б.Мөнхзул

Тооллогын комиссын гишүүн: Н.Оролжмаа

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга Ч.Ганхуяг болон Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатар нарт даалгасугай.



**ЭЧНЭЭ САНАЛЫН ХУУДСААР ЯВУУЛАХ  
АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах;

**АРД КРЕДИТ ББСБ ХК САНАЛ АВАХ ХУУДАС  
(Хэлэлцэх асуудал №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 11 сарын 11-ний өдрөөр тасалбар болгон санал хүлээн авах эчнээ санал хураалтаар явуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингс байр 2 давхар хаягаар ирж хурлын материалтай танилцан санал авах хуудсаар болон [ardcredit.shareholdersmeeting@gmail.com](mailto:ardcredit.shareholdersmeeting@gmail.com) хаягаар саналын хуудсыг илгээн эчнээ санал хураалтаар явуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн санал хураалтын хувьд хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Дүрмийн төсөлд оруулах саналын томъёолол:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_  
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны .... сарын ..... өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_/...../  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



## **АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛД**

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9 сарын 7-ны өдрийн 2019/23 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай зарлаж байна.

**Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх хугацаа:** 2019 оны 10 сарын 1-ний өдөр

**Саналын хуудас хүлээж авах эцсийн өдөр:** 2019 оны 11 сарын 11-ний өдөр

**Компанийн оноосон нэр:** Ард Кредит ББСБ ХК

**Хурлын хэлэлцэх асуудал:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах;

**Бүртгэлийн өдөр:** 2019 оны 9 сарын 26

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2019 оны 11 сарын 11-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар хаягаар ирж хурлын материалтай танилцан саналаа өгөх, цахимаар [ardcredit.shareholdersmeeting@gmail.com](mailto:ardcredit.shareholdersmeeting@gmail.com) хаягаар саналаа ирүүлэх боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар Утас: 77003322, 80114871


**ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ  
АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС  
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар санал өгөх Саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төсөл;

**ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ  
ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

## АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН КОМПАНИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Ард Кредит ББСБ ХК нь /цаашид “Компани” гэх/ Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, Банкны харилцах данстай, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн нэрийн өмнөөс оролцдог хуулийн этгээд байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг нээлттэй хувьцаат компани байна.
- 1.2. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйлжиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийг үндэслэн энэ дүрмийн хүрээнд ашгийн төлөө банк бус санхүүгийн нийтлэг үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Компанийн оноосон нэр: “АРД КРЕДИТ ББСБ” ХК байх ба англиар “ARD CREDIT NBF” Joint Stock Company гэж нэрлэнэ.
- 1.4. Компанийн бэлгэдэл тэмдэг нь  байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна.
- 1.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 1.6. Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхар. Утас: (+976) 77003322, info@ardcredit.com, www.ardcredit.com

### ХОЁР. КОМПАНИЙН ЗОРИЛГО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1. Компани нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зөвшөөрсөн дараах ажил үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:
  - 2.1.1. Зээлийн үйл ажиллагаа,
  - 2.1.2. Гадаад валютын арилжаа,
  - 2.1.3. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх,
  - 2.1.4. Хаалттай өрийн бичиг гаргах,
  - 2.1.5. Итгэлцлийн үйлчилгээ,

- 2.1.6. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх,
- 2.1.7. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ.

2.2. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

#### ГУРАВ.КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 3.1 Компани нь үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:
  - 3.1.1 Харилцагчийн данс, гүйлгээ, мөнгөн хөрөнгийн төрөл, хэмжээтэй холбогдсон нууцыг хадгалах, түүнтэй холбогдсон мэдээллийг гагцхүү тэдний өөрсдийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр болон хуульд заасан үндэслэл журмын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тодорхойлолт гаргаж өгөх;
  - 3.1.2 Төлбөр тооцоог үнэн зөв шуурхай явуулах;
  - 3.1.3 Хуулийн дагуу холбогдох албан татвар төлөх;
  - 3.1.4 Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл болон түүнтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байх;
  - 3.1.5 Компанийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирал бусад ажилтан тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь Компанийн өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байх;
  - 3.1.6 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг барьцаалан зээл олгохгүй байх;
  - 3.1.7 Нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон журмын дагуу ханган биелүүлэх;
- 3.2 Компани нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
  - 3.2.1 Тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх;
  - 3.2.2 Дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр хууль бусаар ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах;
  - 3.2.3 Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;
  - 3.2.4 Иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх;

- 3.2.5 Чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах;
  - 3.2.6 Компанийн тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах;
  - 3.2.7 Зээлийн барьцаа эд хөрөнгийг зээл төлүүлэх зорилгоор эзэмших, худалдаж, борлуулах, үйл ажиллагаа энэ дүрмийн 3.2.1-д хамаарахгүй.
- 3.3 Компани нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.
  - 3.4 Компани нь охин болон хараат компани, салбар төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
  - 3.5 Компани нь өөрийн бизнес үйл ажиллагаатай холбоотой зүйлийг хуулийн дагуу нууцалж болно.

#### ДӨРӨВ.КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

- 4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь компанийн хариуцлагыг өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хүлээнэ.
- 4.3. Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү хариуцсан захирал, Зээл эрхэлсэн захирал, Дотоод аудитор, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна.
- 4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81, 82 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

#### ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.
- 5.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 5.4. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.
  - 5.4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй

- асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- 5.4.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
- 5.4.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 5.4.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;
- 5.4.5 Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьнийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
- 5.4.5.1 Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;
  - 5.4.5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
  - 5.4.5.3 компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
  - 5.4.5.4 Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  - 5.4.5.5 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 5.4.6. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах

эрхтэй.

5.4.7. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

ЗУРГАА. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА БУСАД ҮНЭТ ЦААС,  
ТҮҮНИЙГ ГАРГАХ, ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

- 6.1. Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг хувьцаатай байна.
- 6.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,800,000,000 (хоёр тэрбум найман зуун сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.
- 6.3. Компани нь өөрийн хөрөнгийн хэмжээг ашиг, алдагдлаараа буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг илүү, дутуу байгуулсан хэсгээрээ нэмэгдүүлж, эсхүл хорогдуулж тодорхойлно.
- 6.4. Компанийн хувьцаа эзэмшигч нь дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.
- 6.5. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ.
- 6.6. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
  - 6.6.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
  - 6.6.2 Хувьцаанэмжгаргахболонхудалданавсанхалаасныхувьцаагхүчингүйболгох;
  - 6.6.3 Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх.
- 6.7. Компани нь энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.
- 6.8. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.
- 6.9. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.10. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.11. Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 6.12. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно.



Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн гишүүдийн саналаар тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэл болгоно.

- 6.13. ТУЗ-ийн шийдвэрээр компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 6.14. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
  - 6.14.1. хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;
  - 6.14.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;
  - 6.14.3. компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.
- 6.15. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.
- 6.16. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

#### ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ХЭХ гэх) байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 7.3. ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх, хяналт тавих журам”-ыг баталж мөрдүүлнэ.
- 7.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлаж хуралдуулах бөгөөд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.
- 7.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 7.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 7.7. Энэхүү дүрмийн 7.4 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрт тусгагдсан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болсон

- тохиолдолд компанийн ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдана.
- 7.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Компанийн тухай хуулийн 71.5, 72.1.3, 72.2, 77.1-т тус тус заасны дагуу санал хураалтын кумулятив аргаар явуулна.
  - 7.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
  - 7.10. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.
  - 7.11. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.
  - 7.12. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 7.13. Компанийн саналын эрхтэй хувьцааны энгийн олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуудах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтөлөгчгарынүсэг зурна.Хойшлогдсонхурлаасхэлэлцэхасуудлыгөөрчлөхгүйболно.
  - 7.14. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.5-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.
  - 7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
  - 7.16. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
  - 7.17. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
  - 7.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

#### НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр хувь нийлүүлэгчдийн

хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- 8.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
  - 8.1.2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
  - 8.1.3. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
  - 8.1.4. Компанийн тухай хууль болон хувь нийлүүлэгчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх;
  - 8.1.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй бол ТУЗ-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.
- 8.2. Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээр бүрдэнэ.
  - 8.3. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хэдэн удаа ч хурал зарлан хуралдуулж болно.
  - 8.4. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-өөс түүний оронд өөр хүнийг түр томилно.
  - 8.5. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ. ТУЗ-ийн дарга нь:
    - 8.5.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүрэгтэй.
  - 8.6. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
  - 8.7. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор хороодтой байна. Эдгээр хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
  - 8.8. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
  - 8.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
  - 8.10. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн даргань дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.

- 8.11. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 8.12. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 8.13. 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд ТУЗ-ийн Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг үндэслэн холбогдох шийдвэр, зөвлөмжийг гаргана.
- 8.14. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
- 8.14.1 компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
- 8.14.2 ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;
- 8.14.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
- 8.14.4 өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
- 8.14.5 ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.
- 8.15. Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Дотоод аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, 3. Санхүү, эрсдэл, зээлийн хороог тус тус байгуулна ажиллуулна.
- 8.16. Дотоод аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 8.16.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 8.16.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах;
- 8.16.3 Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- 8.16.4 Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ);

- 8.16.5 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 8.16.6 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.17. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ.Үүнд:
- 8.17.1 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 8.17.2 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол,ажлынтуршлага,харинхараат бусгишүүдийнхувьдэнэхүү дүрмийн8.13-тзаасаншаардлагыгхангажбайгааэсэхэдүнэлэлт,дүгнэлтөгөх;
- 8.17.3 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- 8.17.4 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 8.17.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 8.17.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 8.17.7 Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах;
- 8.17.8 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
- 8.17.9 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 8.17.10 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- 8.17.11 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- 8.17.12 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
- 8.18. Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 8.18.1 Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах;

- 8.18.2 Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөд нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдэлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах;
- 8.18.3 Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 8.18.4 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ хэлцэлүүд, компанийн өөрчлөн байгуулалт (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах г.м) зэрэгт хяналт тавьж ажиллана;
- 8.18.5 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 8.19. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.

### ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1. Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 9.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 9.3. Гүйцэтгэх удирдлагын төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 9.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.
- 9.6. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.
- 9.7. ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хязгаарлаж болно.
- 9.8. Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор

хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.

#### АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРТГЭЛ ТАЙЛАН НОГДОЛ, АШИГ ХУВААРИЛАХ

- 10.1. Компанийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 10.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 сарын 01-нээс 12 сарын 31-нд дуусгавар болно.
- 10.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.
- 10.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 95 дүгээр зүйлийн 95.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 10.5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах "бүртгэлийн өдөр" болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 10.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

#### АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

- 11.1. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 11.2. Компани нь жил бүр санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн шалгалт хийлгэж, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар заавал аудит хийж гүйцэтгүүлэх бөгөөд тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний дотор нийтэд мэдээлнэ.
- 11.3. Компанийн санхүүгийн тайлан үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байна. Компани нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.
- 11.4. Компани нь жил бүрийн санхүүгийн тайландаа хараат бус аудитын байгууллагаар заавал аудит хийлгүүлнэ.
- 11.5. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай сонгогдоно.
- 11.6. Дотоод аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд бусад зүйлсийг дотоод аудитын хорооноос баталсан дотоод журмаар зохицуулна.

- 11.7. Дотоод аудитын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
- 11.8. Дотоод аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 11.9. Дотоод аудитын хороо нь аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.
- 11.10. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудитор төлөх хөлсний хэмжээг заана.
- 11.11. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудитын байгууллагын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.
- 11.12. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 11.13. Дараах этгээдийг компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 11.13.1 компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
- 11.13.2 компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;
- 11.13.3 компаниаудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;
- 11.13.4 компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

#### АРВАН ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

- 12.1. Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах замаар) өөрчлөн байгуулж болно.
- 12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 12.3. ХЭХ-ын шийдвэрээр компанийг татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- 12.4. Дор дурьдсан үндэслэлээр шүүх компанийг татан буулгана
- 12.4.1. Компани дампуурсан;
- 12.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;
- 12.4.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 12.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн хөрөнгө (үүний дотор компанийн эд хөрөнгийг борлуулсны орлого



мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.  
12.6. Компанийг бүртгэхбайгууллагуулсынбүртгэлээсхассанаартатанбуулгасандтооцно

#### АРВАН ГУРАВ. БУСАД НӨХЦӨЛҮҮД

- 13.1. Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын олонхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 13.2. Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа суудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.
- 13.3. Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.
- 13.4. Энэхүү дүрмийг Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт, компанид нэг хувийг хадгална.

## ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

## **АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 11-р сарын 14-ний өдөр

№03/19

Улаанбаатар хот

Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн  
шинэчилсэн найруулга батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2019 оны 11 сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ..... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Сүхбаатар/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 8 сарын 2-ны өдрийн 2018/12 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

## САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

## АРД КРЕДИТ ББСБ ХК САНАЛ АВАХ ХУУДАС (Хэлэлцэх асуудал №1)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар **2019 оны 11 сарын 11-ний өдрөөр тасалбар болгон санал хүлээн авах** эчнээ санал хураалтаар явуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингс байр 2 давхар хаягаар ирж хурлын материалтай танилцан санал авах хуудсаар болон [ardcredit.shareholdersmeeting@gmail.com](mailto:ardcredit.shareholdersmeeting@gmail.com) хаягаар саналын хуудсыг илгээн эчнээ санал хураалтаар явуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн санал хураалтын хувьд хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Дүрмийн төсөлд оруулах саналын томьёолол:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_  
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны .... сарын ..... өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_ /...../  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:





